



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 16/02

Баянбулаг

Бэлчээр түүнийг зохистой ашиглах,
хамгаалах, малын гоц халдварт өвчнөөс
сэргийлэх түр журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.23, 35 дугаар зүйлийн 35.1.13, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь заалт, Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит XVI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Бэлчээр түүнийг зохистой ашиглах, хамгаалах, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх түр журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг нийт иргэдэд мэдээлэх, сурталчилан таниулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, удирдлагаар хангаж, хэрэгжилтийг 2024 оны III улирлын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнахыг Засаг дарга Н.Гансүхэд даалгасугай.

3.Энэхүү журмыг нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөн, холбогдох алба хаагчидтай хамтран иргэний үүргээ хэрэгжүүлж ажиллахыг нийт иргэд, малчдад уриалсугай.

ДАРГА



Б.НАМГАРРЕНЧИН

648803104

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 09 сарын 15 өдрийн 16 дугаар
хуралдааны 16/02 тогтоолын хавсралт

**БЭЛЧЭЭР ТҮҮНИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ, МАЛЫН ГОЦ
ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТҮР ЖУРАМ**

Зорилго: Сумын ард иргэдийн амьжиргааны эх үүсвэр болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах, онд мэнд өвөлжиж, хаваржсанаар малын гоц халдварт өвчингүй эрүүл бүс нутгаа хадгалах, иргэдийн орлогын эх үүсвэрийн тогтвортой байдлыг хадгалах, хамгаалахад оршино.

Мөрдөх хугацаа: 2023.09.15 – 2024.06.01 хүртэл

Хамрах хүрээ: Сумын нутаг дэвсгэр, нийт өрх, ард иргэд

**1. Малчин болон мал бүхий өрх, нийт
ард иргэдийн хүлээх үүрэг**

1.1. Бусад аймаг, сумаас мал худалдаж авах, отор нүүдэл, түрээсээр мал өвөлжүүлэх, хаваржуулах, хөлсөөр маллахыг 2023.09.15-с эхлэн хориглох.

1.2. 2023.09.15-с өмнө сумын нутагт орж ирсэн отор, хөлсөөр хариулах түрээсээр өвөлжиж, хаваржих, малыг малчин тус бүртэй гэрээ байгуулж бэлчээр ашигласны төлбөрийг хонин толгойд шилжүүлсэнээр сарын 2000 (Хоёр мянга) төгрөгөөр тооцож сар бүрийн 25-ний өдрийн дотор сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтын 100 031 855 402 тоот дансанд төвлөрүүлэх. Хугацаа хэтэрсэн тохиолдолд алдангийг гэрээнд заасны дагуу тооцож барагдуулна.

1.3. Бэлчээр ашигласны төлбөрийг Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтад заасан итгэлцүүрээр тооцно. (Бэлчээрийн газраас авах газрын төлбөрийг хонин толгойд шилжүүлсэн малын толгойн тоонд ногдуулахдаа өмнөх жилийн эцэст тоологдсон адууг 6,0, үхрийг 6,0, тэмээг 5,0, ямааг 0,9 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлж тооцно)

1.4. Сумын нутаг дэвсгэрт гэрээгээр хариулагдаж байгаа мал сүргийг малын халдварт, гоц халдварт, угаалга, боловсруулалтын арга хэмжээнд бүрэн хамруулах

1.5. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааг өөр аймаг, сумдын малчдад түрээслэхгүй байх

1.6. Бэлчээрийг хуваарьтай ашиглаж нөөц бэлчээрийг малдаа тохируулан нөөцлөх

2. Төрийн захиргааны байгууллагын хүлээх үүрэг

2.1. Аймгийн Засаг даргын захирамж, түр журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж үүссэн нөхцөл байдлыг сар бүр Засаг даргад мэдээлэх

2.2.Багийн Засаг дарга нар иргэдэд нөхцөл байдлын бодит мэдээллийг шуурхай хүргэж ажиллах

2.3.Өвөлжилт, хаваржилт, малын гоц халдварт өвчний тархалтын болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх сургалт, сурталчилгааг өрх бүрд хүргэж ажиллах

2.4.Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасаг мэдээллийн шуурхай болон үнэн бодит байдлыг хангах, эрсдэлт нөхцөл үүссэн тохиолдолд сумын онцгой комисст яаралтай мэдэгдэж зохих арга хэмжээг авах

3.Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг

3.1.Улс, аймаг, сумын хэмжээний малын гоц халдварт өвчний тархалтын судалгааг гаргаж сар тутам сумын онцгой комисст мэдээлэх

3.2.Малчид ард иргэдэд малын гоц халдварт өвчний талаарх мэдээ мэдээллийг тогтмол хүргэх

3.3.Улсын хэмжээнд хийгдэж буй малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг товлосон цагт нь чанартай хийж гүйцэтгэх

3.4.Малын шилжилт хөдөлгөөнд тавих мал эмнэлгийн системийн хяналтыг бүрэн хангаж ажиллах

3.5.Цаг үеийн шаардлагаар ариутгал халдваргүйжүүлэлт хийхэд техник, багаж тоног төхөөрөмж, эмийн бодисын бэлэн байдлыг хангах

4.Хүлээх хариуцлага

4.1.Эрсдэлт нөхцөл үүссэн тохиолдолд буруутай этгээдийг тогтоож Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудаар хариуцлага тооцно.

4.2.Мал амьтны эрүүл мэндийн тухай, аймгийн Засаг даргын захирамж, энэхүү түр журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.